

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2025 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2026/002/НА-СТА-ЗГТС

---

Чингис хот 2026 он  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

**Тэргүүлэх аудитор:** Ж.Ганбаатар  
Утас: 70562112  
Цахим хаяг: [ganbaatarj@audit.gov.mn](mailto:ganbaatarj@audit.gov.mn)

**Аудитын менежер:** Д.Оюунтуяа  
Утас: 99775390  
Цахим хаяг: [oyuntuyad@audit.gov.mn](mailto:oyuntuyad@audit.gov.mn)

**Аудитор:** Х.Еркегүл  
Утас: 99040705  
Цахим хаяг: [erkegulkh@audit.gov.mn](mailto:erkegulkh@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn) хаягаар авна уу

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3.2 Төлбөрийн акт.....	10
Төлбөрийн акт тогтоогоогүй.....	10
3.2 Албан шаардлага.....	10
3.3 Зөвлөмж.....	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

---

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 428

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны зардлаас нийт 70.0 сая төгрөгийг төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн гаргасан шийдвэрийг өөрчилж үндэслэлгүй тушаал гарган зөрүүтэй олгож, батлагдсан удирдамж, зааврыг баримтлан ажиллаагүй байна. Тухайлбал:

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн онооны эрэмбийн жагсаалтаар өндөр үнэлгээгээр эрэмбэлэгдээгүй 1 иргэнд санхүүгийн дэмжлэг олгох тушаалын хавсралтад өөрчлөлт оруулж баталгаажуулан 10.0 сая төгрөг, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгийг төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгээс тогтоосон дүнг бууруулан 16 иргэнд

нийт 21.0 сая төгрөг дутуу олгосон, төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн эрэмбийн жагсаалтаар өндөр оноогоор эрэмбэлэгдээгүй 5 иргэнд нийт 17.0 сая төгрөг, төсөл сонгон шалгаруулалтад оролцоогүй 1 иргэнд 4.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгийг сонгон шалгаруулалтад ороогүй 2 иргэнд 10.0 сая төгрөг, эрэмбийн жагсаалтаар өндөр оноогоор эрэмбэлэгдээгүй 2 иргэнд 8.0 сая төгрөгийг тушаал гаргаж олгосон зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 1 дүгээр тогтоол болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1,094.8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөрийн орлого 66.3 сая төгрөг, зээлийн эргэн төлөлтөөс 1,263.9 сая төгрөг, нийт 2,425.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 1,274.2 сая төгрөгийг зарцуулж, 1,094.4 сая төгрөгийг дээд шатны байгууллагад төвлөрүүлж, жилийн эцэст 56.4 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд 8 хөтөлбөрийн хүрээнд 159 иргэнд 1,090.0 сая төгрөгийн зээл олгосон, зээлийн эргэн төлөлт 737 иргэн, аж ахуйн нэгжээс 1,263.9 сая төгрөг орж ирсэн байна.

Зээлийн гэрээний хугацаа дууссан 294 иргэн, аж ахуйн нэгжийн 885.7 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар аймгийн прокурорын газарт шилжүүлэн ажилласан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлагыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 70.0 сая төгрөгийн зөрчил илэрч 1 албан шаардлага хүргүүлэв.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 18 зорилтын хүрээнд 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 87.7 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>4,001,426,623.24</b>	<b>3,729,550,482.24</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>4,001,426,623.24</b>	<b>3,729,550,482.24</b>
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	4,001,426,623.24	3,729,550,482.24
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	1,821,516,409.92	1,721,648,574.92
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	190,440,501.00	198,987,648.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	1,330,199,085.00	1,190,980,402.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	385,623,890.32	411,018,020.32
33720	Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл	145,666,415.00	114,366,415.00
33730	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	3,050,000.00	-
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	124,930,322.00	92,549,422.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>4,001,426,623.24</b>	<b>3,729,550,482.24</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	-	<b>184,774,780.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	184,774,780.00
41300	Өглөг	-	184,774,780.00
41360	Бусад өглөг	-	184,774,780.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	23,911,380.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	160,863,400.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>4,001,426,623.24</b>	<b>3,544,775,702.24</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,001,426,623.24	3,544,775,702.24
51200	Хуримтлагдсан үр дүн	4,001,426,623.24	3,544,775,702.24
51210	Өмнөх үеийн үр дүн	4,001,426,623.24	4,001,426,623.24
51220	Тайлант үеийн үр дүн	-	(456,650,921.00)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>4,001,426,623.24</b>	<b>3,729,550,482.24</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,412,541,500.00</b>	<b>1,161,128,440.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,412,541,500.00</b>	<b>858,905,000.00</b>
1200	Өмчийн орлого	3,412,541,500.00	858,905,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,412,541,500.00	858,905,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	793,846,000.00	283,306,460.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	41,580,000.00	66,352,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	2,577,115,500.00	509,246,540.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	<b>302,223,440.00</b>
1310	Улсын төсвөөс	-	302,223,440.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	302,223,440.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>2,640,952,247.56</b>	<b>1,617,779,361.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,640,952,247.56</b>	<b>1,617,779,361.00</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,542,000.00	28,265,960.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,542,000.00	28,265,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,542,000.00	28,265,960.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,589,410,247.56</b>	<b>1,589,513,401.00</b>
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	41,580,000.00	56,452,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,580,000.00	56,452,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,894,421,447.56	1,094,395,959.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,894,421,447.56	1,094,395,959.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	653,408,800.00	438,665,442.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	653,408,800.00	438,665,442.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>771,589,252.44</b>	<b>(456,650,921.00)</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	-	-
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>771,589,252.44</b>	<b>(456,650,921.00)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,412,541,500.00</b>	<b>1,161,128,440.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,412,541,500.00</b>	<b>858,905,000.00</b>
1200	Өмчийн орлого	3,412,541,500.00	858,905,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,412,541,500.00	858,905,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	793,846,000.00	283,306,460.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	41,580,000.00	66,352,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	2,577,115,500.00	509,246,540.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	<b>302,223,440.00</b>
1310	Улсын төсвөөс	-	302,223,440.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	302,223,440.00
<b>14</b>	<b>ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>1,371,635,747.56</b>	<b>1,263,876,141.00</b>
145	Бусад орлого (олз)	1,371,635,747.56	1,263,876,141.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>4,784,177,247.56</b>	<b>2,425,004,581.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,784,177,247.56</b>	<b>2,425,004,581.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>51,542,000.00</b>	<b>28,265,960.00</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,542,000.00	28,265,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,542,000.00	28,265,960.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,732,635,247.56</b>	<b>2,396,738,621.00</b>
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	41,580,000.00	56,452,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,580,000.00	56,452,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,894,421,447.56	1,094,395,959.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,894,421,447.56	1,094,395,959.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,796,633,800.00	1,245,890,662.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,796,633,800.00	1,245,890,662.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>(1,371,635,747.56)</b>	<b>(1,263,876,141.00)</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	-	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>	-	-
<b>9</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,371,635,747.56</b>	<b>1,263,876,141.00</b>
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	1,371,635,747.56	1,263,876,141.00
<b>10</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>	<b>1,371,635,747.56</b>	<b>1,263,876,141.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	-	-
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	0.00	0.00	<b>3,229,837,370.80</b>	<b>3,229,837,370.80</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>3,229,837,370.80</b>	<b>3,229,837,370.80</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00		0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	771,589,252.44	771,589,252.44
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>4,001,426,623.24</b>	<b>4,001,426,623.24</b>
D01	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>4,001,426,623.24</b>	<b>4,001,426,623.24</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>4,001,426,623.24</b>	<b>4,001,426,623.24</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(456,650,921.00)	(456,650,921.00)
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>3,544,775,702.24</b>	<b>3,544,775,702.24</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Хөтөлбөр, төслийн ангилал		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
Код	Үзүүлэлт	Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	Хөрөнгө
11	<b>НЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ОРЛОГО</b>	-	<b>1,850,046,440</b>	<b>819</b>	<b>2,425,004,581</b>	<b>(819)</b>	<b>(574,958,141)</b>
113	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	-	9,900,000	82	66,352,000	(82)	(56,452,000)
117	ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт	-	1,190,146,440	-	1,094,776,440	-	95,370,000
119	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	650,000,000	737	1,263,876,141	(737)	(613,876,141)
2	<b>ЗАРЦУУЛАЛТЫН ДҮН</b>	<b>2,239</b>	<b>1,850,046,440</b>	<b>1,270</b>	<b>2,425,004,581</b>	<b>969</b>	<b>(574,958,141)</b>
2	<b>ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>	<b>1,332</b>	<b>55,297,440</b>	<b>1,270</b>	<b>2,425,004,581</b>	<b>62</b>	<b>(2,369,707,141)</b>
21	2.1 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	82	18,089,280	430	11,302,262	(348)	6,787,018
22	2.2 Ажилд зуучлах үйлчилгээ	1,250	37,208,160	-	5,128,000	1,250	32,080,160
3	<b>ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>	<b>907</b>	<b>1,723,204,000</b>	<b>840</b>	<b>1,229,460,400</b>	<b>67</b>	<b>493,743,600</b>
31	3.1 Хөдөлмөрт бэлтгэх сургалт	555	32,700,000	520	23,350,000	35	9,350,000
32	3.2 Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	112	1,201,920,000	182	904,953,600	(70)	296,966,400
33	3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	77	217,264,000	41	200,000,000	36	17,264,000
34	3.4 Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээ	153	121,920,000	97	62,956,800	56	58,963,200
35	3.5 Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлогдсон хөтөлбөр, төсөл	10	149,400,000	-	38,200,000	10	111,200,000
4	<b>ДӨРӨВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>-</b>	<b>71,545,000</b>	<b>-</b>	<b>28,265,960</b>	<b>-</b>	<b>43,279,040</b>
61	<b>ЗУРГАА. ТӨВЛӨРҮҮЛЭЛТ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1,150,847,959</b>	<b>-</b>	<b>(1,150,847,959)</b>
6110	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - ХЭДСан	-	-	-	613,876,141	-	(613,876,141)
6120	ХБИ ажиллаагүй төлбөрийн орлого - ХЭДСан	-	-	-	56,452,000	-	(56,452,000)
6130	Санхүүжилтын буцаалт - ХЭДСан	-	-	-	480,519,818	-	(480,519,818)

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар 70,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 албан шаардлага хүргүүлэв.

#### **3.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй.

#### **3.2 Албан шаардлага**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны зардлаас нийт 70,000,000.00 /далан сая/ төгрөгийг төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн гаргасан шийдвэрийг өөрчилж үндэслэлгүй тушаал гарган зөрүүтэй олгож, батлагдсан удирдамж, зааврыг баримтлан ажиллаагүй байна. Тухайлбал:

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн онооны эрэмбийн жагсаалтаар өндөр үнэлгээгээр эрэмбэлэгдээгүй 1 иргэнд 10.0 сая төгрөг олгосон;
- Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгийг төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгээс тогтоосон дүнг бууруулан 16 иргэнд нийт 21.0 сая төгрөг дутуу олгосон, төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн онооны эрэмбээр эрэмбэлэгдээгүй /бага оноотой/ 5 иргэнд нийт 17.0 сая төгрөг, төсөл сонгон шалгаруулалтад оролцоогүй 1 иргэнд 4.0 сая төгрөгийг тушаал гарган олгосон;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгийг сонгон шалгаруулалтад ороогүй 2 иргэнд 10.0 сая төгрөг, эрэмбийн жагсаалтаар өндөр оноогоор эрэмбэлэгдээгүй /бага оноотой/ 2 иргэнд 8.0 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 1 дүгээр тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шинэчлэх батлах тухай”-ын 1 дүгээр хавсралтын 5, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/50 тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээ”-ний 6-д “санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа”-ийн 1 дэх хэсэгт “иргэн аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг хэсгийн 1.2-д “Төслийг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулах ба...”, 1.14-д “санхүүгийн дэмжлэг авахаар шалгарсан иргэнтэй тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гэрээ байгуулж, эргэн төлөлтийг хариуцан ажиллана”, 9 дэх хэсэгт “ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг”-ийн 9.1-д “...эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ Засгийн газраас тогтоосон хувь хэмжээгээр байна”, 7-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 8 дахь хэсгийн 8.3-д “ аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага сонгон шалгаруулалтын ажлын хэсэг байгуулж, зохион байгуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

#### **3.3 Зөвлөмж**

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0	0										

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн зарцуулалт	1	70,000.0			1	70,000.0						
Нийт дүн	1	70,000.0			1	70,000.0						

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Зөрчилгүй	0	0						
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Зөрчилгүй	0	0						
Нийт дүн	0	0						